



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар A/263

Улаанбаатар хот

**Тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29, 31 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 6.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ


Ш.ҮНЭНБАТ



Тушаал-2019

115050000833

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 07 дугаар сарын
24-ны өдрийн 1/263 тушаалын хавсралт



Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааг
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Рэнцэнбямба Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

Н.Раднаасэд Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Б.Эрдэнэмөнх Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн

О.Уранчимэг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн

Д.Батбаяр Захиргаа санхүүгийн хэлтсийн нярав

Ажлын хэсгийн нарийн
бичиг:

Б.Мөнхбаатар Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн